



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ноён сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2025/009/НА-СТА-ТТЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг 2025 он</p> | <p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: Ө.Болортуяа Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.25

№

298

танай

-ны №

-т

НОЁН СУМЫН ЗАСАГ ДАРГА
О.НАСАНБУЯН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ноён сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Зэвсэгт хүчний жанжин штаб, аймгийн Цэргийн штабтай хамтран орон нутгийн хамгаалалтын сургалт, дадлагын ажлыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн орлогыг 2,118,782.6 мянган төгрөг байхаар төлөвлөн гүйцэтгэлээр 3,586,542.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 зорилтын хүрээнд 161 арга хэмжээг хэрэгжүүлэн 93.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4625021602

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэгтэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|----------|--|----------------|------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,038.14 | 3,844.50 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 815.54 | 2,399.84 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 477.47 | 314.91 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 903.91 | 288.54 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | 841.21 | 841.21 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 11,458.49 | 14,239.10 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 11,458.49 | 14,239.10 |
| 39200 | Биет хөрөнгө | | 11,310.94 | 14,091.67 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 147.55 | 147.43 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 14,496.62 | 18,083.60 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 6,182.70 | 5,983.91 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 637.26 | 527.19 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 637.26 | 527.19 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 5,545.44 | 5,456.72 |
| 42200 | Урт хугацаат зээл | 20а, 20б | 5,545.44 | 5,456.72 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 8,313.92 | 12,099.69 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 8,313.92 | 12,099.69 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 1,546.74 | 1,546.74 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 19.95 | 19.95 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 6,596.06 | 10,381.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 151.18 | 151.18 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 14,496.62 | 18,083.60 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-----------|--|---------------|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 11,385.13 | 13,103.07 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 2,006.26 | 3,263.46 |
| 110 | Орлогын албан татвар | | 1,128.25 | 2,518.25 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 1,143.22 | 2,549.10 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | (14.97) | (30.85) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 45.79 | 39.44 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 832.22 | 705.77 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 3,052.43 | 3,334.92 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 3,052.43 | 3,334.92 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 6,326.44 | 6,504.69 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 10,129.10 | 8,435.51 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 10,129.10 | 8,435.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 5,563.81 | 6,656.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 394.18 | 768.16 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 50.47 | 93.77 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 102.18 | 516.64 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 404.93 | 3,000.77 |
| 2105 | Нормативт зардал | | 0.10 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 58.90 | 94.80 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 8.94 | 13.86 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 571.38 | 501.33 |

Ноён сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|------------|--|--|-----------------|-----------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,972.72 | 1,667.53 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 4,565.29 | 1,778.64 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 1,256.03 | 4,667.56 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | - | 881.80 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | 1,256.03 | 3,785.76 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|-------------------|-------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 9,324.51 | 11,179.86 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 2,006.26 | 3,263.46 |
| 110 | Орлогын албан татвар | 1,128.25 | 2,518.25 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,143.22 | 2,549.10 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (14.97) | (30.85) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 45.79 | 39.44 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 832.22 | 705.77 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 11.19 | 15.65 |
| 1181 | Газрын төлбөр | 683.45 | 669.62 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 137.58 | 20.51 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 991.81 | 1,328.51 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 991.81 | 1,328.51 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 6,326.44 | 6,587.90 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,500.79 | 4,882.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,500.79 | 4,882.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,738.58 | 3,022.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 572.22 | 1,088.63 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 104.07 | 180.83 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 120.21 | 541.68 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 288.67 | 277.28 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 58.86 | 94.80 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8.94 | 13.86 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 585.04 | 430.29 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,000.58 | 395.40 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,762.21 | 1,860.22 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 823.72 | 6,296.87 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,071.93 | 4,712.58 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,071.93 | 4,712.58 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,071.93 | 4,712.58 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (1,071.93) | (4,712.58) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (248.22) | 1,584.29 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,063.76 | 815.54 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 815.54 | 2,399.84 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|--|--|-----------------------|------------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 7,057.89 | - | 7,057.89 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,057.89 | - | 7,057.89 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | 1,256.03 | - | 1,256.03 |
| 5 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,313.92 | - | 8,313.92 |
| 6 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 8,313.92 | - | 8,313.92 |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,313.92 | - | 8,313.92 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | 3,785.76 | - | 3,785.76 |
| 9 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 12,099.69 | - | 12,099.69 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү |
|-----------|---|-----------------|-----------------------------|-----------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,772.66 | 4,053.57 | 719.09 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,394.86 | 3,770.26 | 624.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,216.50 | 2,029.36 | 187.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 779.36 | 712.96 | 66.40 |
| 210101 | Үндсэн цалин | 325.04 | 321.85 | 3.19 |
| 210102 | Нэмэгдэл | 372.20 | 335.44 | 36.76 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26.46 | 25.95 | 0.51 |
| 210104 | Урамшуулал | 38.19 | 12.34 | 25.86 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17.47 | 17.39 | 0.07 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97.42 | 88.76 | 8.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66.25 | 60.97 | 5.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6.71 | 6.57 | 0.13 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4.44 | 3.86 | 0.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4.44 | 3.71 | 0.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15.59 | 13.65 | 1.93 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 532.80 | 516.64 | 16.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 32.69 | 26.00 | 6.68 |
| 210302 | Түлш, халаалт | 464.70 | 455.74 | 8.96 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 35.41 | 34.90 | 0.52 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 116.00 | 104.21 | 11.79 |
| 210401 | Бичиг хэрэг | 9.66 | 9.65 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 90.47 | 79.38 | 11.09 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5.40 | 4.71 | 0.69 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4.80 | 4.80 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5.67 | 5.66 | 0.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.12 | - | 0.12 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.12 | - | 0.12 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 101.52 | 94.80 | 6.72 |
| 210604 | Урсгал засвар | 101.52 | 94.80 | 6.72 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 13.56 | 13.35 | 0.21 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13.56 | 13.35 | 0.21 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 385.72 | 349.71 | 36.01 |

Ноён сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|------------|---|-----------------|-----------------|-----------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 385.72 | 349.71 | 36.01 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190.00 | 148.94 | 41.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 184.00 | 142.94 | 41.06 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6.00 | 6.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,178.37 | 1,740.89 | 437.47 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 2,118.25 | 1,680.97 | 437.28 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 2,118.25 | 1,680.97 | 437.28 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 60.11 | 59.92 | 0.19 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26.51 | 26.51 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33.60 | 33.41 | 0.19 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 377.80 | 283.31 | 94.49 |
| 223001 | Бусад хөрөнгө | 377.80 | 283.31 | 94.49 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,772.66 | 4,175.88 | 596.78 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,935.29 | 1,731.31 | 203.98 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | - | - | - |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 1,935.29 | 1,731.31 | 203.98 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,509.72 | 2,264.37 | 245.35 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 2,509.72 | 2,264.37 | 245.35 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - | - |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 327.65 | 180.20 | 147.45 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 180.00 | 180.20 | (0.20) |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 147.65 | - | 147.65 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 163.65 | (163.65) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 285.97 | (285.97) |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 48 | 48 | 48 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 4 | 4 | 4 |
| 610001 | Төсвийн байгууллага | 4 | 4 | 4 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 22 | 22 | 22 |
| 620001 | Удирдах ажилтан | 6 | 6 | 6 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | 9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | 6 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1 | 1 | 1 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 22 | 22 | 22 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 10 | 10 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7 | 7 | 7 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 5 | 5 | 5 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|-------------|---|-----------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,665.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 236.38 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 117.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 55.19 |
| 210101 | Үндсэн цалин | 6.27 |
| 210104 | Урамшуулал | 48.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.31 |

Ноён сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | |
|-------------|---|-----------------|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1.07 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2.34 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2.34 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0.51 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.51 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52.19 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52.19 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 119.32 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22.93 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22.93 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 96.40 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 96.40 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,429.27 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,429.27 |
| 221001 | Их засвар | 2,874.40 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,554.87 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,665.65 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,665.65 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,553.02 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3.85 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 108.78 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 29.6 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайлангийн өмнөх үеийн үр дүнг өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн дахин илэрхийлсэн үлдэгдэлтэй тулгахад 29.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 98.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 145.0 саян төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд татварын байцаагчид 3.5 сая төгрөг, Нийгмийн бодлогын мэргэжилтэнд 2.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг тус тус давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргасан тул төлбөрийн акт тогтоох.

5.1 Албан шаардлага

1. Иргэдэд санхүү, татварын боловсрол олгох, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулах төсвөөс 20.0 сая төгрөгийг 15 сумын санхүүгийн албаны албан хаагчдыг БНХАУ-ын Ордос хотод аялуулахад зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлттээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс 48.0 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй, 230.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

3. Өмнөх аудитаар өгсөн 7 зээлдэгч гэрээний дагуу үйл ажиллагаа явуулаагүй, зээл, зээлийн хүүг төвлөрүүлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1-д *"Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Сумын ИТХ-ын 2024 оны 16/02 тогтоолын дагуу ХХОАТ, ТТАМТ, газрын төлбөр, хөрөнгө борлуулсаны орлого, малын албан татвар, нэр заагдаагүй орлогыг тус тус төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

2. Засаг даргын нөөц сангаас Цагдаагийн тасагт 2.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *"Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"*-ын 7.1.-д *"Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-------------|-----------------------------------|-----|--------------------------|-------------|------------|-------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Санхүүгийн байдлын тайлангийн өмнөх үеийн үр дүнг өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн дахин илэрхийлсэн үлдэгдэлтэй тулгахад 29.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 29.6 | | | 1 | 29.6 | 1 | 29.6 | | | | |
| Дүн | 1 | 29.6 | | | 1 | 29.6 | 1 | 29.6 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|-----|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Албан тушаалтны тоо | Дүн |
| 1 | Сумын ИТХ-ын 2024 оны 16/02 тогтоолын дагуу ХХОАТ, ТТАМТ, газрын төлбөр, хөрөнгө борлуулсаны орлого, малын албан татвар, нэр заагдаагүй орлогыг тус тус төсөвт бүрэн төвлөрүүлээгүй | 1 | 1.7 | | | | | 1 | 1.6 | | | | |
| 2 | Засаг даргын нөөц сангаас Цагдаагийн тасагт 2.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| 3 | Тайлант онд татварын байцаагчид 3.5 сая мянган төгрөг, Нийгмийн бодлогын мэргэжилтэнд 2.5 сая төгрөгийн сургалтын | 1 | 6.0 | 1 | 6.0 | | | | | | | | |

Ноён сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|------------|---|----------|-------------|----------|-------------|----------|-------------|----------|------------|--|--|--|
| | төлбөрийн дэмжлэгийг тус тус давхардуулан олгосон | | | | | | | | | | | |
| 4 | Иргэдэд санхүү, татварын боловсрол олгох, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулах төсвөөс 20.0 сая төгрөгийг 15 сумын санхүүгийн албаны албан хаагчдыг БНХАУ-ын Ордос хотод аялуулахад зарцуулсан | 1 | 20.0 | | | 1 | 20.0 | | | | | |
| 5 | Засаг даргын нөөц хөрөнгөөс 48.0 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй, 230.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 71.0 | | | 1 | 71.0 | | | | | |
| 6 | Өмнөх аудитаар өгсөн 7 зээлдэгч гэрээний дагуу үйл ажиллагаа явуулаагүй, зээл, зээлийн хүүг төвлөрүүлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | |
| Дүн | | 6 | 98.7 | 1 | 60.0 | 3 | 91.0 | 2 | 1.6 | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | |
|-----|--|-------------|-----|-----------------------------------|-----|-----------------|-----|---------|-----|--|--|--|
| | | | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | | |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | | |
| | Нийт дүн | | | | | | | | - | | | |